

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

## **ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтын 151-д “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”-аар тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд Захиргааны ерөнхий хуулийг баталж, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно.

Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.7 дахь заалтад зааснаар Үндсэн хуулийн цэцэд хамаарах эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа нь хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй гэж заасан байдаг.

Гэвч Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно.” гэж, мөн зүйлийн 5.1.1 дэх заалтад “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;” гэж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад “захиргааны байгууллага” гэж Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагыг” ойлгоно гэж тус тус зааж Захиргааны ерөнхий хуулийн 5.1.1 дэх заалтад “Засгийн газар” багтана гэж үзэн, Монгол Улсын Засгийн газрын гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянах буюу үйлчлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч байна.

Ийнхүү Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэж, түдгэлзүүлэх, хүчингүй болгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.” гэж, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.” гэж, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэж, Жаран

долдугаар зүйлд “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэж тус тус заасантай зөрчилдөж байна.

Үндсэн хуулийн дээрх үзэл санааг баталгаажуулж Засгийн газрын шийдвэр Захиргааны хэргийн шүүхийн хяналтанд байх эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 02 тоот Дүгнэлт гаргасан болно.

Дээрх дүгнэлтэд Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна. Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна. Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байна гэж дурдсан байна.

Өөрөөр хэлбэл, дээрх дүгнэлтэд “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан” гэсэн 4 дүгээр зүйлийн “...дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн 4.1 дэх хэсгийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэж, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна” гэж Үндсэн хуулийн зүйл, заалтыг туйлын тодорхой тайлбарлан шийдсэн байдаг.

Иймээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалт хүчингүй болж байсан байна. Гэтэл 2015 онд Улсын Их Хурлаас баталсан Захиргааны ерөнхий хуулийн 5.1.1 дэх заалтад “Засгийн газар” гэж шууд нэрлэн заагаагүй боловч ерөнхий шинжээр нь Засгийн газрыг багтаасан хэмээн үзэж түүний шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх бодитоор хянаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдөхөд хүргэж байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц 2005 оны 02 тоот дүгнэлтээ гаргахдаа эшилсэн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль хүчингүй болсон боловч Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 тоот дүгнэлт өнөөдөр хуулийн хүчин төгөлдөр хэвээр байгаа буюу уг 02 тоот дүгнэлт гарснаас хойш өнөөг хүртэл Үндсэн хуульд өөрчлөлт ороогүй болно.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслөөр Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт, түүний тайлбар болон 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтаар үүссэн ойлгомжгүй, хоёрмол утгатай байдлыг засаж хуулийг нэг мөр ойлгох боломжийг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төсөл 1 зүйлтэй байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.” гэж, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.” гэж, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэж, Жаран долдугаар зүйлд “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэж заасан зохицуулалт хийгээд Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 02 тоот Дүгнэлтэд нийцүүлэн Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлийг тодорхой болгох буюу хуулийн үйлчлэлд Засгийн газрын шийдвэр, түүнийг хэрэгжүүлсэн төрийн захирганы төв болон төрийн захиргааны бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа хамаарахгүй байхаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдснаар хууль тогтоомжийн зөрчил арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдлүүд нь харилцан бие биеэсээ харьцангуй хараат бус, бие дааснаар үйл ажиллагаа хэрэгжүүлэх, Захиргааны ерөнхий хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх боломж бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөж журмын тухай хуулийг зэрэгцүүлэн боловсруулна.